



БАТЛАВ:   
 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
 ГАЗРЫН ДАРГЫН АЛБАНҮҮРГИЙН ТҮР ОРЛОН  
 ГҮЙЦЭТГЭГЧ  ДАРИУНБАТ  
 2022 ОНЫ 09 ДУГААР САРЫН 20 НЫ ӨДӨР

**МӨРӨН СУМЫН 9.12 ДУГААР БАГИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМ ДАГУУХ  
ГЭРЭЛТҮҮЛЭГ БОЛОН ЯВГАН ЗАМЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
ДААЛГАВАР**

2022.09.19

№3Д-2022/125

Мөрөн сум

1	Зураг төсөв зохиох үндэслэл	Хөвсгөл аймгийн засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр. Хөвсгөл аймгийн "Хөгжсөн Хөвсгөл" 2016-2030 он хөтөлбөр. Сумын Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Ээлтэй Мөрөн" үйл ажиллагааны хөтөлбөр
2	Барилга байгууламжийн нэр, байршил	Хөвсгөл аймаг, Мөрөн сумын 9,12-р баг
3	Архитектур төлөвлөлтийн шаардлага, хүчин чадал.	Орчны өнгө үзэмжийг сайжруулах, Ажлын талбайн ойролцоох зам талбай, зүлэг ногоог гэмтээхгүйгээр ажлыг гүйцэтгэх.
4	Барилга байгууламжийн бүрэлдэхүүн	<p>9,12 дугаар багийн босоо тэнхлэгийн авто замын урд уулзвараас хатуу хучилттай авто зам дуустал нийт 1900 метр газар явган хүний зам болон гэрэлтүүлгийг шинэчлэх ажил хийгдэнэ.</p> <p><b>Явган зам:</b> Явган зорчигчийн замыг хатуу хучилттай авто замын баруун гар талд хүний хөдөлгөөний эрчимтэй уялдуулан төлөвлөж өгнө.</p> <p>Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009, MNS 5682:2006 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам.</p> <p>Техникийн шаардлага стандартыг баримтална.</p> <p>Явган хүний зам, талбайн төлөвлөлт техникийн ерөнхий шаардлага MNS6808:2019, Замын байгууламж. Явган замын төлөвлөлттэй уялдуулан хогийн сав(ангилян ялгах), сандал гэх мэт архитектурын бага хэлбэрийн элементүүдийг төлөвлөнө.</p> <p><b>Гэрэлтүүлэг:</b> Гэрэлтүүлэг нь хатуу хучилттай авто замын баруун гар талд байрлана. Зураг төсвийг гүйцэтгэхдээ Монгол улсын норм ба дүрэм Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг БНБД 23 – 02 – 08 нормыг үндэслэнэ. Гэрэлтүүлэгчийн техникийн үзүүлэлт : Хүчдэл 220В цагаан өнгийн гэрэлтэй, IP65хамгаалалтын зэрэгтэй, 85В - 265В хүчдэлийн хэлбэлзэл даах чадвартай, 100Вм чадалтай, 50000 цагаас багагүй ашиглалтын хугацаатай, -45 + 45 ажиллах чадвартай, 3 жилийн үйлдвэрлэлийн баталгаатай</p>

		<p>гэрэлтүүлэгч байна.</p> <p><i>Гэрэлтүүлгийн шугам:</i> Тусгаарлагчтай шугам нь 660В болон 1000В-ын цахилгаан эрчим хүчийг дамжуулах хүчин чадалтай ашиглалтын үед +70 хүртэл халхад тэсвэртэйгээс гадна гадаад орчинд , -50 + 50-д ажиллах тэсвэртэй дамжуулагч утас байна.</p> <p><i>Гэрэлтүүлэгийн тулгуур:</i> 8 м-ийн өндөртэй стандартын шаардлага хангасан бөгөөд үйлдвэрлэлийн аргаар будаж бэлтгэсэн хуймал төмөр хийцтэй байна.</p>
5	Барилгын үндсэн бүтээц, материал	<p>Явган зам – зориулалтын бетон хавтан байна.</p> <p>Гэрэлтүүлэг – Бетон суурьтай, металл шон байх ба сусад материал стандартын шаардлага хангасан материал сонгож төлөвлөнө.</p>
6	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр.	Цахилгааны эх үүсвэр – техникийн нөхцлийн дагуу
7	Зураг төслийн иж бүрдэл	<p><u>Зургийн төслийн иж бүрдэл</u></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ажлын зураг /батлагдсан/</li> <li>2. Ажлын төсөв /батлагдсан/</li> </ol> <p><u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u></p> <p>Тохижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх</p>
8	Зураг төсөв зохиох үе шат	<p>✓ 1 үе шаттай</p> <p>✓ Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.</p>
9	Зураг төслийн байгууллага	“ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” Монгол улсын хуулийн дагуу зөвлөх үйлчилгээгээр сонгон шалгаруулна. Зураг төслийн тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж зураг төсөл боловсруулах дүрмийн дагуу /БНБД 11-01-98/ хийж гүйцэтгэнэ.
10	Хөрөнгө оруулагч байгууллага	Орон нутгийн хөгжлийн сангаас
11	Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх хугацаа	2022 он
12	Онцгой нөхцөл	<p>✓ Үерийн ус зайлуулах суваг шуудууг тооцож төлөвлөж өгсөн байх.</p> <p>✓ Зураг төслийг газар дээр нь хэмжилт хийж гүйцэтгэх.</p> <p>✓ Ажлын талбайг ашиглагч байгууллагатай зөвшилцөж хязгаарыг тогтооно.</p> <p>✓ Хог хаягдал булах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн хогийн цэг Хог хаягдлын тухай хуулийн 17, 18 -р зүйлд заасан шаардлагыг хангасан байна</p>

13	Галын аюулгүй байдлын нөхцөл	"Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНБД 21-01-02, "Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм" БНБД 21-02-02, "норм дүрмүүдээс холбогдох заалтуудыг авч төвлөнө.
14	Байгаль орчны үнэлгээ	Шаардлагатай нөхцөлд үнэлгээг тухай бүрд нь хийлгэнэ.

**ХЯНАСАН:**

АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР:

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА:

**ЗУРГИЙН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛСАН:**

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН:

Handwritten signatures and names in black ink over a red rectangular stamp. The names are: /Х.ДАВААСҮРЭН/, /Б.ЭНХЖАРГАЛ/, and /Б.БААСАНЖАВ/.